



ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ  
**ХОРООНЫ ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 26 өдөр

№ 08

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

“Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, Хадгаламжийн Даатгалын Үндэсний Хорооны 2013 оны 9 дүгээр сарын 25-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Банкны тайлан болон мэдээ мэдээлэл ирүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хадгаламжийн Даатгалын Корпорацийн гүйцэтгэх захирал (Б.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЖАВХЛАН

## **БАНКНЫ ТАЙЛАН БОЛОН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ ЖУРАМ**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Банкны тайлан болон мэдээ, мэдээлэл ирүүлэх журам /цаашид “журам” гэх/-ын зорилго нь хадгаламжийн даатгалын үйл ажиллагаанд оролцож буй банк /цаашид “банк” гэх/ Хадгаламжийн даатгалын корпорацид /цаашид “ХДК” гэх/ хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тайлан болон мэдээ, мэдээллээр хангахтай холбогдон үүсэх эрх, үүргийн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ХДК нь Хадгаламжийн даатгалын хуулийн 21.1.1-р зүйл болон 21.1.2-р зүйлд заасны дагуу банкны тайлан болон мэдээ, мэдээллийг банкнаас авах эрхтэй.

### **ХОЁР.БАНКНЫ ҮҮРЭГ**

- 2.1. Хадгаламжийн даатгалын хуулийн 29.1-р зүйлд заасны дагуу банк нь хадгаламжийн тайланг нэг болон хоёрдугаар хавсралтын дагуу бэлтгэн, энэхүү журамд заасан хугацаанд ХДК-д хүргүүлнэ.
- 2.2. Хадгаламжийн даатгалын хуулийн 29.2-р зүйлд заасны дагуу банк нь нэмэлт мэдээллийг мөн ХДК -ийн тогтоосон хугацаа, загварын дагуу хүргүүлнэ.
- 2.3. Хэрэв ХДК нэмэлт тайлан, мэдээлэл авахдаа тодорхой хугацаа заагаагүй бол банк хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан гаргаж өгөх үүрэгтэй.
- 2.4. Банкнаас ХДК-д хүргүүлэх тайлан болон мэдээ, мэдээллийг холбогдох удирдах албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

### **ГУРАВ.ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ХЭЛБЭР БОЛОН ХУГАЦАА**

- 3.1. Банк нь тайланг тухайн сарын сүүлийн өдрийн байдлаар бэлтгэн дараа сарын 10-ны өдрийн дотор цаасаар болон цахим хэлбэрээр ХДК-д хүргүүлнэ.
- 3.2. Хэрэв банк дээрх хугацаанд тайланг ирүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ тухай ХДК-д нэн даруй мэдэгдэх ба ХДК тайлан ирүүлэх хугацааг ажлын 5 хүртэлх хоногоор сунгаж болно.
- 3.3. Банк тайланг алдаатай хүргүүлсэн тохиолдолд энэ тухай ХДК-д яаралтай мэдэгдэж, ажлын 3 хоногт багтаан залруулсан тайланг дахин хүргүүлнэ.
- 3.4. Хэрэв банкны илгээсэн тайланг алдаатай болохыг ХДК илрүүлбэл банкинд бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд банк залруулсан тайланг ажлын 5 хоногт багтаан ХДК-д хүргүүлнэ.
- 3.5. Банкнаас авах нэмэлт тайлан болон мэдээ, мэдээллийн аргачлалыг мэдээлэл авах хүсэлтийн хамтаар хүргүүлэх бөгөөд банк нь тэрхүү аргачлалын дагуу бэлтгэнэ.

- 3.6. Банкнаас авах нэмэлт тайлан болон мэдээ, мэдээлэл нь нэг удаагийн эсвэл тогтмол хугацаагаар байж болно.
- 3.7. Банк нь тайланг бэлтгэхдээ ХДК-иас ирүүлсэн цахим маягтын дагуу зөвхөн бөглөх бөгөөд нэмэлт тайлбар, хүснэгт хийхгүй.

### **ДӨРӨВ.ХАРИУЦЛАГА**

- 4.1. Хадгаламжийн даатгалын хуулийн 29.4-р зүйлд заасны дагуу банк нь Корпорацид хүргүүлсэн тайлан болон мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.
- 4.2. Банк нь энэхүү журмын дагуу тайлан, мэдээг ирүүлэхдээ ХДК-иас тавьсан шаардлагыг биелүүлээгүй, дутуу биелүүлсэн, үл хүндэтгэсэн, санаатай болон санамсаргүйгээр алдаагаа давтсан тохиолдолд эдгээр нь ХДК-ийн үнэлэх эрсдэлийн дүнд нөлөөлнө.
- 4.3. Хэрэв банк нь Хадгаламжийн даатгалын тухай хуулийн 29-р зүйлд заасан чиг үүргээ биелүүлээгүй тохиолдолд энэ хуулийн 30-р зүйл болон 30.2, 30.2.2-р зүйлд заасны дагуу банкинд захиргааны шийтгэл ногдуулна.
- 4.4. Банк нь удаа дараа үүргээ биелүүлээгүй бөгөөд ХДК-ийн үйл ажиллагаанд хүндрэл учруулсан тохиолдолд энэ тухай Монголбанкинд мэдэгдэж, банкны тухай хуулийн 68 дугаар зүйлийн дагуу шийтгэл ногдуулна.

### **ТАВ.БУСАД**

- 5.1. Банкнаас ирүүлсэн тайлан, мэдээллийн талаарх бүртгэлийг гуравдугаар хавсралтад заасны дагуу ХДК хөтөлнө.
- 5.2. Бүртгэлийг хөтлөхдөө ХДК-д ирүүлсэн огноог мөрдлөг болгоно.
- 5.3. Энэхүү журам нь батлагдсан өдрөөсөө эхлэн мөрдөгдөнө.
- 5.4. Шаардлагатай тохиолдолд Үндэсний хороо нь энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

## ДААТГАЛЫН ХУРААМЖ ТООЦОХ ТАЙЛАН

Банкны нэр:

Огноо:

№	Үзүүлэлт	Тайлбар	Харилцах, хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	Харилах, хадгаламжийн дансны тоо	Харилцах, хадгаламж эзэмшигчдийн тоо
A	Нийт харилцах, хадгаламж	(1+2)			
1	Иргэдийн нийт харилцах, хадгаламж				
2	Хуулийн этгээдийн нийт харилцах, хадгаламж				
B	Даатгалд хамаарахгүй нийт харилцах, хадгаламж (хуулийн 7.1)	(3+4+5)			
3	Нэргүй, дугаарласан, эсвэл хуурамч нэртэй харилцах, хадгаламж (хуулийн 7.1.1)				
4	Нэргүй хадгаламжийн сертификат болон бусад төрлийн нэргүй санхүүгийн хэрэгсэл (хуулийн 7.1.2)				
5	Нэрлэсэн үнээр эргэж төлөгдөхгүй харилцах, хадгаламж (хуулийн 7.1.3)				
	<b>ДААТГАЛЫН ХУРААМЖ ТООЦОХ ХАДГАЛАМЖ</b>	<b>(A-B)</b>			
C	Даатгалд хамаарахгүй нийт этгээд (хуулийн 7.2)	(6+...+11)			
6	Банк (хуулийн 7.2.1)				
7	Төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага (хуулийн 7.2.2)				
8	Эрүүл мэндийн, тэтгэврийн болон нийгмийн албан журмын даатгалын сан (хуулийн 7.2.3)				
9	Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан банкны холбогдох этгээд (хуулийн 7.2.4)				
10	Сүүлийн гурван жилийн хугацаанд банкны санхүүгийн тайланд аудит хийсэн аудитор болон аудитын байгууллага (хуулийн 7.2.5)				
11	Монголбанкны хяналт шалгалтын тайлангаар банкны санхүүгийн байдал муудахад нөлөөлсөн, банкны үйлчилгээ авахдаа санхүүгийн давуу эрх эдэлсэн нь тогтоогдсон хадгаламж эзэмшигч (хуулийн 7.2.6)	(12+13+14)			
12	Гүйлгээний төрөл, эрсдэлийн түвшин, зээлдэгчийн төлбөрийн чадвар болон барьцааны төрөл зэргийг харгалзан үзэхэд бусад зээлдэгчээс онцгой нөхцөлтэй зээл авсан (хуулийн 7.2.6.а)				
13	Банкны бусад хадгаламж эзэмшигчээс илт бага хүүтэй зээл авсан (хуулийн 7.2.6.б)				
14	Монголбанкны статистик мэдээллээр хадгаламж эзэмшигчдийн авч байгаа хадгаламжийн дундаж хүүгээс 50 хувиар илүү хүү авсан (хуулийн 7.2.6.в)				
D	Нийт даатгагдах харилцах, хадгаламж	(A-B-C)			
15	Иргэн				
16	Хуулийн этгээд				
17	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134.9-д заасны дагуу битүүмжилсэн болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 11.1-д заасны дагуу гүйлгээг нь түдгэлзүүлсэн дансны хадгаламж эзэмшигч (хуулийн 7.4)				

Тайлан бэлтгэсэн:

/ /

Тайлан хянасан:

/ /

Хүлээн авсан:

/ /

### ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ТАЙЛАН

Банкны нэр:

Огноо:

/мян.төг/

№	Үзүүлэлт	Нийт харилцах, хадгаламж				Өндөр хүүтэй харилцах, хадгаламжийг хассан дүн				Зээл болон өр төлбөртэй харилцах, хадгаламж				Цэвэршүүлсэн харилцах, хадгаламж		
		Эзэмшигч- дийн тоо	Дансны тоо	Үлдэгдэл	Хуримтлагд- сан хүү	Эзэмшигч- дийн тоо	Дансны тоо	Үлдэгдэл	Хуримтлагд- сан хүү	Зээлдэгч- дийн тоо	Дансны тоо	Зээлийн үлдэгдэл	Хуримтлагд- сан хүүгийн өр	Эзэмшигч- дийн тоо	Дансны тоо	Үлдэгдэл
1	Иргэд															
	20 сая хүртэл															
	20 саяас 30 сая хүртэл															
	30 саяас 40 сая хүртэл															
	40 саяас 50 сая хүртэл															
	50 саяас 100 сая хүртэл															
	100 саяас дээш															
2	Байгууллага															
	20 сая хүртэл															
	20 саяас 30 сая хүртэл															
	30 саяас 40 сая хүртэл															
	40 саяас 50 сая хүртэл															
	50 саяас 100 сая хүртэл															
	100 саяас дээш															
3	Холбогдох этгээд					x	x	x	x	x	x	x	x	x	x	x
4	Банк					x	x	x	x	x	x	x	x	x	x	x
5	Төрийн байгууллага					x	x	x	x	x	x	x	x	x	x	x
6	Нийгмийн даатгалын сан					x	x	x	x	x	x	x	x	x	x	x
	<b>Нийт</b>															

Тайлан бэлтгэсэн: / /

Тайлан хянасан: / /

Хүлээн авсан: / /

## ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ АРГАЧЛАЛ

Нийт харилцах, хадгаламж эзэмшигчдийг сегментээр нь иргэд, байгууллага, холбогдох этгээд, банк, төрийн байгууллага, нийгмийн болон бусад сангууд гэж ангилна.

- “Иргэд” гэдэгт Монгол улсын болон гадаад улсын иргэд орох ба холбогдох этгээд орохгүй.
- “Байгууллага” гэдэгт хувийн болон улсын өмчит байгууллагууд орох ба холбогдох хуулийн этгээд орохгүй.
- “Холбогдох этгээд” гэдэгт Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан этгээдүүд орно.
- “Банк” гэдэгт Монгол улсын болон гадаад улсын банк орно.
- “Төрийн байгууллага” гэдэгт засгийн газар, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллага болон бусад төрийн оролцоотой байгууллага орно.
- “Нийгмийн даатгалын сан” гэдэгт нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн сан, тэтгэврийн сан, тэтгэмжийн сан болон бусад нийгмийн халамжийн сангууд орно.

1. Харилцах, хадгаламжийн үлдэгдлийг тооцоходоо нэг эзэмшигчийн нэр дээр хэдэн данс байгааг тоолж, тэдгээр данснуудын үлдэгдэл болон хуримтлагдсан хүүг нийлбэрчилнэ. Ингэж нийлбэрчилсэн үлдэгдлүүдийг тайланд заасан интервалаар ангилна. Интервалын дээд хилийн утга нь дараагийн интервалын доод хилийн утганд орохгүй. Интервалд ангилсны дараа оногдох интервалын бүлгүүдэд эзэмшигчдийн тоо, тэдгээрийн данснуудын тоо, үлдэгдэл болон хуримтлагдсан хүүгийн нийлбэрийг тусгана. Жишээ нь:

№	Эзэмшигч	Дансны дугаар	Валют	Хүүгийн хувь	Үлдэгдэл /төг/	Хуримтлагдсан хүү /нэгж.төг/
1	Билгүүн	4053...61	MNT	13%	10,000,000	10,000
2	Билгүүн	4053...62	USD	1%	400,000	200
3	Билгүүн	4053...63	USD	3%	350	0
4	Билгүүн	4053...64	MNT	10%	5,000	65
5	Билгүүн	4053...65	MNT	10%	15,000,000	15,000
					<b>25,405,350</b>	<b>25,265</b>
6	Наранцэцэг	4065...15	MNT	12%	250,000,000	2,500,000
7	Наранцэцэг	4065...16	MNT	19%	35,000,000	350,000
8	Наранцэцэг	4065...17	MNT	3%	10,000	100
					<b>285,010,000</b>	<b>2,850,100</b>
9	Болд	3021...54	MNT	12%	5,000,000	170,000
10	Батболд	4011...11	MNT	21%	3,000,000	411,000
11	Солонго	2051...32	MNT	11%	31,000,000	61,000
12	Солонго	2052...88	MNT	10%	51,900,000	4,700,500
					<b>82,900,000</b>	<b>4,761,500</b>
13	Ариунгэрэл	4054...21	USD	5%	41,650	1,650
14	Ариунгэрэл	1061...02	MNT	10%	18,000,000	3,451,000
					<b>18,041,650</b>	<b>3,452,650</b>
	<b>Нийт</b>				<b>419,357,000</b>	<b>11,670,515</b>



						/нэгж.төг/
№	Эзэмшигчийн нэр	Эзэмшигчдийн тоо	Дансны тоо	Үлдэгдэл	Хуримтлагдсан хүү	
1	Билгүүн	1	5	25,405,350	25,265	20 саяас 30 сая хүртэл
2	Наранцэцэг	1	3	285,010,000	2,850,100	100 саяас дээш
3	Болд	1	1	5,000,000	170,000	20 сая хүртэл
4	Батболд	1	1	3,000,000	411,000	20 сая хүртэл
5	Солонго	1	2	82,900,000	4,761,500	50 саяас 100 сая хүртэл
6	Ариунгэрэл	1	2	18,041,650	3,452,650	20 сая хүртэл
Нийт		6	14	419,357,000	11,670,515	



						/мян.төг/
№	Үзүүлэлт	Харилцах, хадгаламж				
		Эзэмшигчдийн тоо	Дансны тоо	Үлдэгдэл	Хуримтлагдсан хүү	
1	Иргэд	6	14	419,357.00	11,670.52	
	20 сая хүртэл	3	4	26,041.65	4,033.65	
	20 саяас 30 сая хүртэл	1	5	25,405.35	25.27	
	30 саяас 40 сая хүртэл	-	-	-	-	
	40 саяас 50 сая хүртэл	-	-	-	-	
	50 саяас 100 сая хүртэл	1	2	82,900.00	4,761.50	
	100 саяас дээш	1	3	285,010.00	2,850.10	

2. Өндөр хүүтэй харилцах, хадгаламжийг хассан депозитын үлдэгдлийг тооцохдоо харилцах, хадгаламж гэсэн төрлөөр валют тус бүрээр тайлант хугацааны жигнэсэн дундаж хүүнээс 50%-иар илүү хүүтэй харилцах, хадгаламжийг тодорхойлно. Нийт харилцах, хадгаламжийн данснуудаас өндөр хүүтэй харилцах, хадгаламжийн дансыг хасч, үлдсэн данснуудын эзэмшигч болон тэдгээрийн дансыг тоолж, үлдэгдэл болон хуримтлагдсан хүүг нийлбэрчилнэ. Энэхүү нийлбэрүүдийг оногдох интервалд тусгана.

Жишээ нь: Дээрх депозитын дэлгэрэнгүй үлдэгдлээс жигнэсэн дундаж хүүг тооцоход төгрөгийн хүү 12.2%, ам.долларын хүү 1.4% байна. Энэ тохиолдолд 150%-иас илүү буюу төгрөгийн хадгаламжийн хүү 18.3%, ам.долларын хадгаламжийн хүү 2.1%-иас илүү гарсан бол өндөр хүүтэй харилцах, хадгаламж гэж үзнэ. Дээрх жишээнд зөвхөн MNT, USD хадгаламжийн бүтээгдэхүүнийг авч үзсэн тул харилцах дансны хувьд өндөр хүүг тусад нь тооцно.

							/нэгж.төг/
№	Эзэмшигч	Дансны дугаар	Валют	Хүүгийн хувь	Үлдэгдэл /төг/	Хуримтлагдсан хүү	
1	Билгүүн	4053...61	MNT	13%	10,000,000	10,000	
2	Билгүүн	4053...62	USD	1%	400,000	200	
3	Билгүүн	4053...63	USD	3%	350	0	Өндөр хүүтэй
4	Билгүүн	4053...64	MNT	10%	5,000	65	
5	Билгүүн	4053...65	MNT	10%	15,000,000	15,000	
					<b>25,405,350</b>	<b>25,265</b>	
6	Наранцэцэг	4065...15	MNT	12%	250,000,000	2,500,000	
7	Наранцэцэг	4065...16	MNT	19%	35,000,000	350,000	Өндөр хүүтэй
8	Наранцэцэг	4065...17	MNT	3%	10,000	100	
					<b>285,010,000</b>	<b>2,850,100</b>	
9	Болд	3021...54	MNT	12%	5,000,000	170,000	
10	Батболд	4011...11	MNT	21%	3,000,000	411,000	Өндөр хүүтэй
11	Солонго	2051...32	MNT	11%	31,000,000	61,000	
12	Солонго	2052...88	MNT	10%	51,900,000	4,700,500	
					<b>82,900,000</b>	<b>4,761,500</b>	
13	Ариунгэрэл	4054...21	USD	5%	41,650	1,650	Өндөр хүүтэй
14	Ариунгэрэл	1061...02	MNT	10%	18,000,000	3,451,000	
					<b>18,041,650</b>	<b>3,452,650</b>	
Нийт					419,357,000	11,670,515	



/нэгж.төг/					
№	Эзэмшигчийн нэр	Эзэмшигчдийн тоо	Дансны тоо	Үлдэгдэл /төг/	Хуримтлагдсан хүү
1	Билгүүн	1	4	25,405,000	25,265
2	Наранцэцэг	1	2	250,010,000	2,500,100
3	Болд	1	1	5,000,000	170,000
4	Солонго	1	2	82,900,000	4,761,500
5	Ариунгэрэл	1	1	18,000,000	3,451,000
Нийт		5	10	381,315,000	10,907,865

20 саяас 30 сая хүртэл  
100 саяас дээш  
20 сая хүртэл  
50 саяас 100 сая хүртэл  
20 сая хүртэл



/мян.төг/					
№	Үзүүлэлт	Өндөр хүүтэй харилцах, хадгаламжийг хассан депозит			
		Эзэмшигчдийн тоо	Дансны тоо	Үлдэгдэл	Хуримтлагдсан хүү
1	Иргэд	5	10	381,315.00	10,907.87
	20 сая хүртэл	2	2	23,000.00	3,621.00
	20 саяас 30 сая хүртэл	1	4	25,405.00	25.27
	30 саяас 40 сая хүртэл	-	-	-	-
	40 саяас 50 сая хүртэл	-	-	-	-
	50 саяас 100 сая хүртэл	1	2	82,900.00	4,761.50
	100 саяас дээш	1	2	250,010.00	2,500.10

3. Зээл болон өр төлбөртэй харилцах, хадгаламжийн үлдэгдлийг тооцохдоо харилцах, хадгаламж эзэмшигч нь тухайн банкнаас авсан зээлийн болон ямар нэгэн төлбөрийн өртэй тохиолдолд эзэмшигчийн нэр дээрх нийт зээлийн болон авлагын дансуудыг тоолж, тэдгээр данснуудын үлдэгдэл болон хуримтлагдсан хүүгийн өрийг нийлбэрчилнэ. Ингэж нийлбэрчилсэн үлдэгдлүүдийг өндөр хүүтэй харилцах, хадгаламжийг хассан депозитод ангилсан интервалаар ангилна. Интервалд ангилсны дараа оногдох интервалын бүлгүүдэд зээл болон өр төлбөртэй эзэмшигчдийн тоо, тэдгээрийн данснуудын тоо, зээлийн болон авлагын нийт үлдэгдэл мөнхүү хуримтлагдсан хүүгийн өрийн нийлбэрийг тусгана.

Жишээ нь: Дээрх жишээний хувьд хадгаламж эзэмшигч Билгүүн, Наранцэцэг нар нь зээлтэй бөгөөд өндөр хүүтэй харилцах, хадгаламжийг хассан депозитын интервалаар Билгүүн нь 20 саяас 30 сая, Наранцэцэг нь 100 саяас дээш ангилалд орсон. Билгүүн, Наранцэцэг нарын хичнээн хэмжээний зээл, өр төлбөртэйгээс үл хамааран энэхүү ангиллаар тэдний зээлийг ангилна.

/нэгж.төг/				
№	Зээлдэгч	Дансны дугаар	Зээлийн үлдэгдэл	Хуримтлагдсан хүүгийн өр
1	Шүрээ	100..10	30,000,000	1,500,000
2	Билгүүн	100..28	1,200,000	650,000
3	Билгүүн	100..35	250,000	12,500
			<b>1,450,000</b>	<b>662,500</b>
4	Наранцэцэг	100..04	230,000,000	10,000,000
5	Батбаатар	100..61	82,000,000	3,500,000
6	Хандаа	100..33	2,000,000	130,000
7	Нацагдорж	100..89	8,500,000	2,600,000
...	...		...	...
Нийт				

харилцах, хадгаламжтай  
харилцах, хадгаламжтай  
харилцах, хадгаламжтай





/нэгж.төг/					
№	Зээлдэгч	Зээлдэгчдийн тоо	Дансны тоо	Зээлийн үлдэгдэл	Хуримтлагдсан хүүгийн өр
1	Билгүүн	1	2	1,450,000	662,500
2	Наранцэцэг	1	1	230,000,000	10,000,000
	Нийт	2	3	231,450,000	10,662,500

20 саяас 30 сая хүртэл  
100 саяас дээш



/мян.төг/					
№	Үзүүлэлт	Зээл болон өр төлбөртэй харилцах, хадгаламж			
		Зээлдэгчдийн тоо	Дансны тоо	Зээлийн үлдэгдэл	Хуримтлагдсан хүүгийн өр
1	Иргэд	2	3	231,450.00	10,662.50
	20 сая хүртэл	-	-	-	-
	20 саяас 30 сая хүртэл	1	2	1,450.00	662.50
	30 саяас 40 сая хүртэл	-	-	-	-
	40 саяас 50 сая хүртэл	-	-	-	-
	50 саяас 100 сая хүртэл	-	-	-	-
	100 саяас дээш	1	1	230,000.00	10,000.00

4. Цэвэршүүлсэн харилцах, хадгаламжийн үлдэгдлийг тооцохдоо өндөр хүүтэй харилцах, хадгаламжийг хассан депозитын дэлгэрэнгүйгээс зээл болон өр төлбөртэй этгээдүүдийн банкинд төлөх нийт өрийн хэмжээг хасна. Хадгаламж эзэмшигчийн дансны тооноос зээлийн дансны тоо нь бага байвал зөрүүгээр эсрэг тохиолдолд хадгаламж эзэмшигчийн дансны тоогоор цэвэршүүлсэн дансны тоог гаргана. Ингэж тооцохдоо депозитын үлдэгдэл дээр депозитын хуримтлагдсан хүүг, зээлийн үлдэгдэл дээр нь зээлийн хуримтлагдсан хүүгийн өрийг тус тус нэмнэ. Хэрэв тухайн эзэмшигч ямар нэгэн зээл болон өр төлбөргүй тохиолдолд харилцах, хадгаламжийн үлдэгдэл дээр депозитын хуримтлагдсан хүүг нь нэмнэ. Зээл болон өр төлбөрийг цэвэршүүлсний дараа депозитын үлдэгдлийг тайланд заасан интервалаар ангилна. Ангилсан дүнгүүдийг оногдох интервалд тусгана.

Жишээ нь: Дээрх жишээнд харилцах, хадгаламж эзэмшигч Билгүүн 2.1 сая төгрөгийн, эзэмшигч Наранцэцэг 240 сая төгрөгийн зээлтэй. Өндөр хүүтэй харилцах, хадгаламж хассан депозитын ангиллаар эзэмшигч Наранцэцэг нь 100 саяас дээш интервалд багтаж байсан бол зээлийн төлбөрийг хассаны дараа 12.5 сая төгрөгийн хадгаламжтай үлдэж 20 сая хүртэл интервалд ангилагдсан байна.

/нэгж.төг/					
№	Эзэмшигчийн нэр	Эзэмшигчдийн тоо	Дансны тоо	Үлдэгдэл	Хуримтлагдсан хүү
1	Билгүүн	1	4	25,405,000	25,265
2	Наранцэцэг	1	2	250,010,000	2,500,100
3	Болд	1	1	5,000,000	170,000
4	Солонго	1	2	82,900,000	4,761,500
5	Ариунгэрэл	1	1	18,000,000	3,451,000
	Нийт	5	10	381,315,000	10,907,865

20 саяас 30 сая хүртэл  
100 саяас дээш  
20 сая хүртэл  
50 саяас 100 сая хүртэл  
20 сая хүртэл



/нэгж.төг/					
№	Зээлдэгч	Зээлдэгчдийн тоо	Дансны тоо	Зээлийн үлдэгдэл	Хуримтлагдсан хүүгийн өр
1	Билгүүн	1	2	1,450,000	662,500
2	Наранцэцэг	1	1	230,000,000	10,000,000
	<b>Нийт</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>231,450,000</b>	<b>10,662,500</b>

20 саяас 30 сая хүртэл  
100 саяас дээш



/нэгж.төг/				
№	Эзэмшигчийн нэр	Эзэмшигчдийн тоо	Дансны тоо	Үлдэгдэл
1	Билгүүн	1	2	23,317,765
2	Наранцэцэг	1	1	12,510,100
3	Болд	1	1	5,170,000
4	Солонго	1	2	87,661,500
5	Ариунгэрэл	1	1	21,451,000
	<b>Нийт</b>	<b>5</b>	<b>7</b>	<b>150,110,365</b>

20 саяас 30 сая хүртэл  
20 сая хүртэл  
20 сая хүртэл  
50 саяас 100 сая хүртэл  
20 саяас 30 сая хүртэл



/мян.төг/				
№	Үзүүлэлт	Цэвэршүүлсэн харилцах, хадгаламж		
		Эзэмшигчдийн тоо	Дансны тоо	Үлдэгдэл
1	Иргэд	5	7	150,110.37
	20 сая хүртэл	2	2	17,680.10
	20 саяас 30 сая хүртэл	2	3	44,768.77
	30 саяас 40 сая хүртэл	-	-	-
	40 саяас 50 сая хүртэл	-	-	-
	50 саяас 100 сая хүртэл	1	2	87,661.50
	100 саяас дээш	-	-	-

5. Холбогдох этгээд, банк, төрийн байгууллага болон нийгмийн даатгалын сан зэрэгт зөвхөн 1-р хэсгийн тооцооллыг гүйцэтгэнэ.

